



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/257-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум

2024 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: [cheegii9989@gmail.com](mailto:cheegii9989@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАГ	Төрийн аудитын газар
ТБОНӨХБАУХА худалдах авах тухай	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ П.СЭЛЭНГЭ ТАНАА

2024.2.23 № СЗА-2024/258-НА-СТА-ТЦЦЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд БШУЯ-наас 12,240.5 мянган төгрөгийн ном, ширээ сандал, сумын ЗДНХ-нөөс 5,266.0 мянган төгрөгийн камер, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 45,887.5 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	121,876,071.38	244,268,639.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,074,532.19	139,055,473.50
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,074,532.19	139,055,473.50
3121	Төгрөг	18,074,532.19	139,055,473.50
31211	Төрийн сангийн харилцах	18,074,532.19	139,055,473.50
35	БАРАА МАТЕРИАЛ	103,801,539.19	105,213,165.84
351	Түүхий эд материал	71,559,029.42	76,367,867.07
3511	Тусгай зориулалттай материал	71,559,029.42	76,367,867.07
354	Хангамжийн материал	21,761,741.00	17,890,641.00
3545	Барилгын засварын материал	6,088,000.00	6,088,000.00
3547	Бусад хангамжийн материал	15,673,741.00	11,802,641.00
355	Биологийн хөрөнгө	10,480,768.77	10,954,657.77
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,791,021,905.84	1,754,637,761.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,791,021,905.84	1,754,637,761.70
392	Биет хөрөнгө	1,324,383,156.10	1,288,391,511.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,224,744,512.01	1,224,744,512.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-137,205,387.00	-172,113,116.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	205,453,236.24	261,195,836.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-88,991,930.37	-136,056,059.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,579,593.67	72,711,593.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,984,040.08	-47,138,424.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	89,748,149.47	89,748,149.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,758,021.92	-22,197,527.40
39217	Ном	15,797,044.08	17,496,548.58
393	Биет бус хөрөнгө	466,638,749.74	466,246,249.86
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,011,250.26	-1,403,750.14
39303	Бусад биет бус хөрөнгө	466,000,000.00	466,000,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,912,897,977.22	1,998,906,401.04
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,912,897,977.22	1,998,906,401.04
51	Засгийн газрын хувь оролцоо	1,912,897,977.22	1,998,906,401.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,200,326,267.55	1,200,326,267.55
51101	Өмч: - төрийн	1,200,326,267.55	1,200,326,267.55
512	Хуримтлагдсан үр дүн	-359,593,988.53	-273,585,564.71
5121	Өмнөх үеийн үр дүн	-359,593,988.53	-359,593,988.53
5122	Тайлант үеийн үр дүн		86,008,423.82
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,072,165,698.20	1,072,165,698.20
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,912,897,977.22	1,998,906,401.04

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,053,533,974.44	1,505,231,273.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,949,731,784.59	58,045,819.80
120	Нийтлэг татварын бус орлого	1,949,731,784.59	58,045,819.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,832,788.00	7,668,988.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		7,668,988.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,828,940,483.17	17,506,504.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	115,958,513.42	32,870,327.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,103,802,189.85	1,447,185,454.02
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	976,928,900.00	1,330,012,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	976,928,900.00	1,330,012,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	126,873,289.85	115,173,054.02
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	126,873,289.85	115,173,054.02
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,140,635,997.22	1,419,222,850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,140,635,997.22	1,419,222,850.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,082,614,697.22	1,339,794,950.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	760,006,858.54	926,127,107.33
210101	Үндсэн цалин	519,299,881.13	624,895,029.06
210102	Нэмэгдэл	217,926,830.86	261,976,703.27
210104	Урамшуулал	22,780,146.55	39,255,375.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,218,051.27	114,374,455.44
210201	Тэтгэврийн даатгал	65,060,999.76	79,730,925.63
210202	Тэтгэмжийн даатгал	7,499,617.29	9,196,857.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,119,745.34	7,291,602.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,473,706.82	1,680,855.17
210205	Эрүүл мэндийн даатгал	14,063,982.06	16,474,215.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,877,470.85	103,140,454.02
210301	Гэрэл, цахилгаан	5,019,710.85	7,339,014.02
210302	Түлш, халаалт	85,206,120.00	87,681,900.00
210303	Цэвэр, бохир ус	6,651,640.00	8,119,540.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,910,130.79	13,059,685.65
210408	Бараа материал акталсны зардал	9,910,130.79	13,059,685.65

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,432,600.00	32,885,200.00
210604	Урсгал засвар	7,432,600.00	32,885,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,262,000.00	8,500,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,810,900.00	3,120,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,451,100.00	5,380,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,907,585.77	141,707,747.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,038,705.00	29,014,998.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,115,993.44	10,734,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,752,887.33	101,958,248.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,021,300.00	79,427,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,021,300.00	79,427,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,339,000.00	47,601,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,682,300.00	31,826,900.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,912,897,977.22	86,008,423.82
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,912,897,977.22	86,008,423.82

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,108,634,977.85	1,454,854,442.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,832,788.00	7,668,988.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,832,788.00	7,668,988.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,832,788.00	7,668,988.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		7,668,988.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,103,802,189.85	1,447,185,454.02
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	976,928,900.00	1,330,012,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	976,928,900.00	1,330,012,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	126,873,289.85	115,173,054.02
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	126,873,289.85	115,173,054.02
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,050,726,135.66	1,285,805,900.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,050,726,135.66	1,285,805,900.71

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	992,704,835.66	1,206,378,000.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	760,006,858.54	926,127,107.33
210101	Үндсэн цалин	519,299,881.13	624,895,029.06
210102	Нэмэгдэл	217,926,830.86	261,976,703.27
210104	Урамшуулал	22,780,146.55	39,255,375.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,218,051.27	114,374,455.44
210201	Тэтгэврийн даатгал	65,060,999.76	79,730,925.63
210202	Тэтгэмжийн даатгал	7,538,085.03	9,196,857.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,062,043.72	7,291,602.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,444,856.02	1,680,855.17
210205	Эрүүл мэндийн даатгал	14,112,066.74	16,474,215.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,877,470.85	103,140,454.02
210301	Гэрэл, цахилгаан	5,019,710.85	7,339,014.02
210302	Түлш, халаалт	85,206,120.00	87,681,900.00
210303	Цэвэр, бохир ус	6,651,640.00	8,119,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,065,600.00	12,032,600.00
210604	Урсгал засвар	6,065,600.00	12,032,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,262,000.00	8,500,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,810,900.00	3,120,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,451,100.00	5,380,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,274,855.00	42,203,083.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,444,255.00	30,580,583.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,830,600.00	11,622,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,021,300.00	79,427,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,021,300.00	79,427,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,339,000.00	47,601,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,682,300.00	31,826,900.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	57,908,842.19	169,048,541.31
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39,834,310.00	48,067,600.00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	39,834,310.00	48,067,600.00
	Дотоод эх үүсвэрээр	39,834,310.00	48,067,600.00
222001	Тоног төхөөрөмж	39,784,310.00	48,067,600.00
223001	Бусад хөрөнгө	50,000.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-39,834,310.00	-48,067,600.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,074,532.19	120,980,941.31

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		18,074,532.19
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		139,055,473.50

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,200,326,267.55	1,072,165,698.20	-359,593,988.53	1,912,897,977.22
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			86,008,423.82	86,008,423.82
19	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,200,326,267.55	1,072,165,698.20	-273,585,564.71	1,998,906,401.04

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,495,585,600.00	1,333,873,500.71	161,712,099.29	89.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,495,585,600.00	1,285,805,900.71	209,779,699.29	86.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,409,349,200.00	1,206,378,000.71	202,971,199.29	85.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,038,172,400.00	926,127,107.33	112,045,292.67	89.2
210101	Үндсэн цалин	687,796,000.00	624,895,029.06	62,900,970.94	90.9
210102	Нэмэгдэл	300,909,200.00	261,976,703.27	38,932,496.73	87.1
210104	Урамшуулал	49,467,200.00	39,255,375.00	10,211,825.00	79.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,771,600.00	114,374,455.44	15,397,144.56	88.1
210201	Тэтгэврийн даатгал	88,244,700.00	79,730,925.63	8,513,774.37	90.4
210202	Тэтгэмжийн даатгал	10,381,700.00	9,196,857.28	1,184,842.72	88.6

210203	ҮОМШӨ-ний даатгал	8,305,300.00	7,291,602.23	1,013,697.77	87.8
210204	Ажилгүйдлийн даатгал	2,076,400.00	1,680,855.17	395,544.83	81.0
210205	Эрүүл мэндийн даатгал	20,763,500.00	16,474,215.13	4,289,284.87	79.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,809,000.00	103,140,454.02	24,668,545.98	80.7
210301	Гэрэл, цахилгаан	7,797,000.00	7,339,014.02	457,985.98	94.1
210302	Түлш, халаалт	106,050,000.00	87,681,900.00	18,368,100.00	82.7
210303	Цэвэр, бохир ус	13,962,000.00	8,119,540.00	5,842,460.00	58.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,032,600.00	12,032,600.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	12,032,600.00	12,032,600.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,768,200.00	8,500,300.00	2,267,900.00	78.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,120,300.00	3,120,300.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,647,900.00	5,380,000.00	2,267,900.00	70.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,795,400.00	42,203,083.92	48,592,316.08	46.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,172,800.00	30,580,583.92	48,592,216.08	38.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,622,600.00	11,622,500.00	100.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,236,400.00	79,427,900.00	6,808,500.00	92.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,236,400.00	79,427,900.00	6,808,500.00	92.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,409,500.00	47,601,000.00	8,808,500.00	84.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,826,900.00	31,826,900.00	-2,000,000.00	106.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		48,067,600.00	-48,067,600.00	
	Дотоод эх үүсвэрээр		48,067,600.00	-48,067,600.00	
222001	Тоног төхөөрөмж		48,067,600.00	-48,067,600.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,495,585,600.00	1,454,854,442.02	40,731,157.98	97.3
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,330,012,400.00	1,332,012,400.00	-2,000,000.00	100.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,330,012,400.00	1,330,012,400.00	0.00	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	139,841,600.00	115,173,054.02	24,668,545.98	82.4
132001	Орон нутгийн төсвөөс	139,841,600.00	115,173,054.02	24,668,545.98	82.4
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС			1,330,012,400.00	0.0
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт			1,330,012,400.00	0.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,668,988.00	7,668,988.00	0.00	100.0
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,668,988.00	7,668,988.00	0.00	100.0
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР	18,062,612.00		18,062,612.00	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,062,612.00	18,074,532.19	-11,920.19	100.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		139,055,473.50	-139,055,473.50	#DIV/0!
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52	49	3	94.2

6	Удирдах ажилтан	1	1	0	100.0
7	Гүйцэтгэх ажилтан	41	38	3	92.7
8	Үйлчлэх ажилтан	10	10	0	100.0
11	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	491	485	6	98.8

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь “*Сурах арга барилттай хүнлэг амьдрах ухаантай оролцоо сайтай шийдвэр гаргах чадвартай бүтээлч,эрүүл авьяаслаг зөв хүүхэд төлөвшүүлэх.*” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Тус байгууллага нь дараах чиг үүрэгтэй ажилласан байна. Үүнд:

- Боловсролд хэрэгжиж буй шинэчилсэн хуулийг сургалцагч, эцэг, эх багш ажилтан, иргэдэд сурталчлан таниулах, хамтын оролцоотой хэрэгжүүлэх,
- Сургуулийн менежментийг сайжруулж үнэлгээний үр дүнд суурилан, сурлагын амжилтыг ахиулах,
- Суралцагчдыг гадаад хэл шинжлэх ухаан, технологи, математик болон цахим платформд суурилсан нэмэлт хөтөлбөрт хамруулан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх,

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх,худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 86,008.4мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	18,074.5	139,055.5	120,980.9
Авлага			
Бараа материал	103,801.5	105,213.2	1,411.6
Үндсэн хөрөнгө	1,791,021.9	1,754,637.8	(36,384.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,912,898.0</b>	<b>1,998,906.4</b>	<b>86,008.4</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,912,898.0	1,998,906.4	86,008.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,912,898.0</b>	<b>1,998,906.4</b>	<b>86,008.4</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 139,055.5 мянган төгрөг болж 120,980.9 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 105,213.2 мянган төгрөг болж 1,411.6 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-наас 11,977.7 мянган төгрөгийн ном, хичээлийн хэрэглэгдэхүүн, сумын ЗДНХ-өөс 20,852.6 мянган төгрөгийн урсгал засварын материал, НҮБ-ын хүүхдийн санаас 40.0 мянган төгрөгийн номыг үнэ төлбөргүй авч, төсвийн хөрөнгөөр 79,793.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж, үйл ажиллагаанд 98,192.8 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулан, сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/24 дүгээр
- тушаалын дагуу цаашид ашиглах боломжгүй 13,059.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассанаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,754,637.8 мянган төгрөг болж 36,384.1 мянган төгрөгөөр буурсан нь БШУЯ-наас 12,240.5 мянган төгрөгийн ном, ширээ сандал, сумын ЗДНХ-нөөс 5,266.0 мянган төгрөгийн камер, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 48,067.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан болон 101,958.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 816,659.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 119,685.8 мянган төгрөг нийт 936,345.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 86,974. мянган төгрөгөөр буюу цалин хөлсийг 83,414.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 14,920.2 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 14,284.9 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 5,392.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 31,037.8 мянган төгрөгөөр буруулж нийт 1,023,319.6 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 11 дүгээр сард цалин хөлсийг 373,808.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 60,264.7 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 4,140.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 37,714.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тогтмол зардлыг 3,661.7 мянган төгрөгөөр, буруулж нийт 1,495,585.6 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,495,585.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,333,873.5 мянган төгрөгийг зарцуулж, 161,712.1 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,333,873.5 мянган төгрөг буюу 89.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 128,235.1 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 8,808.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 24,668.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

				/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,059.2	2,684.8	374.4	87.8
		2	80312- Сургалт семинар	1,661.2	1,661.2	-	100.0
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	4,915.1	4,915.0	0.1	100.0
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	56,409.5	47,601.0	8,808.5	84.4
		5	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	35,341.9	35,192.0	149.9	99.6
		6	81823- Боловсролын багшийн сургалт	6,883.1	6,882.9	0.2	100.0
		7	81834- Боловсролын стандарт сургалт	1,062,799.4	947,482.2	115,317.2	89.1
		8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	189,038.2	174,645.0	14,393.2	92.4
		9	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	2,337.5	2,337.5	0.0	100.0
		10	83603-сурах бичгийн түрээс	3,120.3	3,120.3	-	100.0
		11	83603- Дээд шатны төсвөөс	2,211.2	2,211.1	0.1	100.0
		12	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	127,809.0	103,140.5	24,668.5	80.7
		13	80802 Дээд шатны төсөв	2,000.0	2,000.0	-	100.0
<b>Нийт</b>				1,495,585.6	1,333,873.5	161,712.1	89.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайланг худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнс 48,522.2 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан боловч гүйцэтгэгч ирээгүй учраас “Шанзан ташуур”, “Амьд шим” ХХК нүүрс, “Япсомо” ХХК-иудтай шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг компанийн захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,140,635.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,406.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх 48,522.2 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу [tender.gov.mn](http://tender.gov.mn)-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүйгээс “Шанзан ташуур”, “Амьд шим” ХХК нүүрс, “Япсомо” ХХК-иудтай шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“Пийк Ом аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 214 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивээгүй 2,503.6 мянган төгрөгийн, шилэн дансны цахим цэсэнд - 2 мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрч 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Зөвлөмж	1		1	
Албан шаардлага	1	2,503.6	1	2,503.6	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>2,503.6</b>	<b>2</b>	<b>2,503.6</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “ Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу нягтлан бодогч О.Оюундэлгэрийн ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 875.3 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг илрээгүй байна.

Аудитаар 397.5 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 төлбөрийн акт тогтоосон байна.

### **5.1 Төлбөрийн акт**

1. Жилийн эцэс буюу тайлант оны 12 дугаар сард шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг 9 багшид 25.0 хувиар тооцон /өмнөх саруудад 10-15 хувиар тооцож олгож байсан/ 397.5 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан **шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн** үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр олгосон ур чадварын нэмэгдлийн зөрүүг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга		Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал								
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн							
Ур чадварын нэмэгдлийг илүү олгосон		1	397.5	1	397.5																
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>397.5</b>	<b>1</b>	<b>397.5</b>																

/мянган төгрөгөөр/